

ҮСХ-ны даргын 2009 оны 12-р сарын 29-ны өдрийн 01/177
тоот тушаалын хавсралтаар батлав.

Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

Улаанбаатар хот
2009 он

АГУУЛГА

I.	Нийтлэг үндэслэл	2
II.	Ойлголт, тодорхойлолт	2
III.	Хамрах хүрээ.....	5
IV.	Бараа, үйлчилгээ, ажил мэргэжлийн үндсэн ангилал	6
V.	Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр, давтамж.....	7
VI.	Мэдээлэл цуглуулах.....	17
VII.	Мэдээллийг хэрэглэгчдэд тархаах.....	17
	Хавсралт 1. Хийсвэр жишээ.....	19
	Хавсралт 2. “А” аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл	23

МОНГОЛ УЛСЫН ДОТООД ХУДАЛДААНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

I. Нийтлэг үндэслэл

Худалдаа нь үйлдвэрлэгчээс бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, ямар нэг боловсруулалт хийхгүйгээр үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд хүргэдэг онцлогтой салбар юм. Энэ утгаараа худалдаа нь үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хооронд зуучийн үүрэг гүйцэтгэдэг.

Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг.

Энэхүү аргачлалын зорилго нь худалдааны салбарын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, мэдээллийг боловсруулагч, хэрэглэгчдэд статистикийн үзүүлэлт, тэдгээрийн ойлголт, тодорхойлолтыг нэг мөр болгож, нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг Нэгдсэн үндэстний байгууллагын статистикийн хэлтсээс эрхлэн гаргасан “Дотоод худалдааны статистикийн олон улсын зөвлөмж, 2008”-д тулгуурлан боловсруулсан.

II. Ойлголт, тодорхойлолт

Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглах нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- 2.1. **Эдийн засгийн үйл ажиллагаа**нд зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг, хамруулна. Худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд, материал; зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бараа, үйлчилгээ, зах зээлд худалдах, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээг хамруулна;
- 2.2. **Дахин борлуулах** гэж жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж худалдан авсан бараанд ямар ч боловсруулалт хийлгүйгээр цаашид дахин худалдахыг;
- 2.3. **Бараанд боловсруулалт хийлгүй борлуулах.** Барааны гадаад төрх, онцлогт дараах өөрчлөлтүүдийг оруулаагүй байвал барааг боловсруулалт хийгдээгүй гэж үзнэ. Үүнд: ангилах, угсрах, холих, савлах, баглах, жижиглэж савлах, хадгалах, ХАА-н бүтээгдэхүүнийг цэвэрлэх, хатаах гэх мэт үйл ажиллагааг;

- 2.4. **Жижиглэнгийн худалдаа** гэж хүн амын эцсийн хэрэглээнд зориулсан барааг дэлгүүр, лангуу, үүргийн худалдаа болон захиалга, дуудлагаар худалдах үйл ажиллагааг;

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын G дүгээр салбарын 47 дахь дэд салбар болох *Хүнс, ундаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, шатахууны жижиглэн худалдаа, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжийн төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, гэр ахуйн бусад тоног төхөөрөмжийн төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, соёл, амралтын барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, захиалга, загвар танилцуулгаар хийдэг жижиглэн худалдаа, төрөлжсөн бус барааны жижиглэн худалдаа* зэрэг үйл ажиллагаа хамаарна.

- 2.5. **Электрон худалдаа** гэж бизнес эрхлэгч хувь хүн, Засгийн газар, төрийн болон хувийн бусад байгууллага хоорондоо бараа, үйлчилгээг интернэтээр дамжуулан худалдах, худалдан авахыг ойлгоно.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын G дүгээр салбарын 47 дахь дэд салбар болох *Шуудан болон интернэтийн захиалгаар хийгддэг жижиглэн худалдааны* үйл ажиллагаа хамаарна.

- 2.6. **Бөөний худалдаа** гэж шинэ, хуучин барааг жижиглэнгийн худалдаачдад худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагаас хэрэглэгчдэд, бөөний худалдаачдад эргүүлэн борлуулах, бөөний агентлаг хэлбэрээр хувь хүмүүс, компаниудаас бараа худалдан авах, эсвэл худалдах хэлбэрийн үйл ажиллагаа;

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын G дүгээр салбарын 46 дахь дэд салбар болох *төлбөр, эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, материал, амьд мал, хүнс, архи, ундаа, тамхины бөөний худалдаа; гэр ахуйн барааны бөөний худалдаа; машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн нэмэлт тоног төхөөрөмжийн бөөний худалдаа, хог ба хаягдал; машин тоног төхөөрөмж, хангамжийн материалын бөөний худалдаа, төрөлжсөн бус барааны бөөний худалдаа* зэрэг үйл ажиллагаа хамаарна.

- 2.7. **Үйл ажиллагааны чиглэл** аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа, хоёрдогч үйл ажиллагаа, туслах үйл ажиллагаа гэж ялгана.

2.7.1 **Үндсэн үйл ажиллагаа.** Үндсэн үйл ажиллагааг тодорхойлохын тулд шаталсан бүтэцтэй “ихээс бага руу хуваарилах арга”-аар тодорхойлно. Ингэхдээ **нэгдүгээрт**, ЭЗҮАСА-ын салбарыг тодорхойлохдоо олон үйл ажиллагаатай нэгжийн нэмэгдсэн өртгийн дүнд хамгийн өндөр хувь эзэлж байгаа салбарыг эхлэн сонгоно. **Хоёрдугаарт**, салбар дотроо хамгийн их хувь эзэлж байгаа дэд салбарыг сонгоно. **Гуравдугаарт**, салбар дотор нь хамгийн их хувь эзэлж байгаа ЭЗҮАСА-ын бүлгийн түвшинд, дараа нь дэд бүлгийн түвшинд тус тус сонгоно. Нэмэгдэл өртгийн мэдээллийг ашиглах боломжгүй тохиолдолд

борлуулалтын орлого, цалингийн хэмжээ, хөрөнгийн үзүүлэлтийг ашиглан үндсэн үйл ажиллагааг тогтоож болно (Жишээг хавсралт 2-оос харна уу).

2.7.2 **Хоёрдогч үйл ажиллагаа.** Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг хоёрдогч үйл ажиллагаа гэж үзнэ. Хоёрдогч үйл ажиллагаа нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас 10-аас дээш хувийг эзэлж байвал хоёрдогч үйл ажиллагаагаар бүртгэнэ. Энэ нь олон үйл ажиллагаатай орон нутгийн нэгжийн хувьд ч адил байна (Жишээг хавсралт 2-оос харна уу).

2.7.3 **Туслах үйл ажиллагаа.** Туслах үйл ажиллагаанд аж ахуйн нэгжийн санхүү, бичиг хэрэг, тээвэрлэх, савлах, сурталчлах зэрэг туслах үйл ажиллагаа хамаарна. Туслах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь үндсэн үйлдвэрлэлд завсрын хэрэглээ болдог бөгөөд салбарын ангилалд бие дааж тусгагдахгүй. Жишээлбэл удирдах газар, байгууллага тусдаа байлаа ч гэсэн тухайн нэгждээ хамаарна.

2.8. **Үндсэн үнэ** гэж үйлдвэрийн газар нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гаргасан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг хэлнэ. Үүний зэрэгцээ үндсэн үнэд татаасыг оруулж тооцно. ҮТС-д энэ үнийг цэвэр үйлдвэрлэлийн хүрээний тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний гаргалтын буюу аливаа бүтээгдэхүүнд ногдуулсан татвар, түүнтэй төстэй бусад хураамжуудыг төлөхийн өмнөх үнэ гэж үздэг. Иймээс үндсэн үнийн бүрэлдэхүүнд бараа, үйлчилгээний татварыг оруулдаггүй.

2.9. **Үйлдвэрлэгчийн үнэ** гэж үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татваруудыг (нэмэгдсэн өртгийн албан татвараас бусад) нэмж, татаасыг хасч тооцсон үнийг хэлнэ.

2.10. **Худалдан авагчийн үнэ** гэж үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.

2.11. **Ажиллагч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэгд хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

2.11.1 **Байнгын ажилтан** гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

- 2.11.2 **Бүрэн бус цагаар ажиллагч** гэж хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг боловч долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг иргэнийг;
- 2.11.3 **Гэрээт ажиллагч** гэж ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс, урамшуулал авдаг 2.11.1-д хамаарахгүй иргэнийг;
- 2.12. **Ажилласан хүн цаг** гэж ердийн ажлын өдрийн хугацаанд жинхэнэ ажилласан цаг, нэмэлт /илүү цагаар ажилласан цаг/, бусад /ажлын байрандаа ажил хүлээлцэх, тайлан, багаж хэрэгсэл зэргээ бэлдэх эсвэл засвар үйлчилгээ хийх зэрэгт зарцуулсан хугацаа, хөдөлмөрийн гэрээгээр ажлын байранд цалинтай байхаар тусгагдсан хүлээлт/ ажил гүйцэтгэсэн цаг хугацаагаар хэмжигдэнэ.
- 2.13. **Ажиллаагүй хүн цаг** гэж ажиллаагүй боловч цалин хөлс олгогдож байгаа ажлын цагт, ээлжийн амралт, сул зогсолт, цалин олгогдох өвчтэй байх хугацаа, бусад цалинтай чөлөөнүүд, цалин олгогдох үдийн завсарлагаа, ажиллагчдын ажлын байранд байсан үгийг эс харгалзсан цалин хөлс олгогдох ажлын цагууд орно.

III. Хамрах хүрээ

Хамрах хүрээ. Монгол улсын нутаг дэвсгэрт дотоод худалдааны салбарын үйл ажиллагаа эрхэлж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, цэг, иргэдийг хамруулна.

Дотоод худалдааны салбарын үйл ажиллагаанд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал (ISIC.4.0)-ын дагуу моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээ болон бусад барааны бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээг хамруулна. Тэдгээр нь дараах төрлүүдээр нарийвчлан ангилагдана. Үүнд:

- 3.1 Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ.
- 3.1.1 Моторт тээврийн хэрэгслийн худалдаа
 - 3.1.2 Моторт тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ
 - 3.1.3 Моторт тээврийн хэрэгслийн сэлбэг эд ангийн худалдаа

- 3.1.4 Мотоцикл, түүний эд анги, сэлбэг хэрэгслийн худалдаа, засвар, үйлчилгээ
- 3.2 Бөөний худалдааны үйл ажиллагаа. Бөөний худалдааг дараах төрлөөр ангилна. Үүнд:
- 3.2.1. Өөрийн эзэмшлийн бөөний худалдаа;
- 3.2.2. Комиссын барааны худалдаа.
- 3.3 Жижиглэн худалдааны үйл ажиллагаа. Жижиглэн худалдааг дараах төрлөөр ангилна. Үүнд:
- 3.3.1 Дэлгүүрийн жижиглэн худалдаа;
- 3.3.2 Дэлгүүрийн бус жижиглэн худалдаа.

Худалдааны салбарын ангиллыг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1.

**Худалдааны салбарын үйл ажиллагааны
стандарт ангилал**

Бүлгийн нэр	Стандарт ангиллын код
Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	45
Моторт тээврийн хэрэгслийн худалдаа	451
Моторт тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	452
Моторт тээврийн хэрэгслийн сэлбэг эд ангийн худалдаа	453
Мотоцикл, түүний эд анги, сэлбэг хэрэгслийн худалдаа, засвар, үйлчилгээ	454
Бөөний худалдаа	46
Өөрийн эзэмшлийн бөөний худалдаа	462-466, 469
Төрөлжсөн бөөний худалдаа	462-466
Төрөлжсөн бус бөөний худалдаа	469
Комиссын барааны худалдаа	461
Жижиглэн худалдаа	47
Дэлгүүрийн жижиглэн худалдаа	471-477
Төрөлжсөн их дэлгүүр	472-477
Төрөлжсөн бус их дэлгүүр	471
Дэлгүүрийн бус жижиглэн худалдаа	478
Мухлаг, дэлгүүрээр дамжуулан худалдах	478
Бусад	478

IV. Бараа, үйлчилгээ, ажил мэргэжлийн үндсэн ангилал

- 4.1. Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцоход дараах ангиллыг ашиглана. Үүнд:
- 4.1.1. Дотоод худалдааны салбарын үйл ажиллагааг Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангиллын 4 оронгийн түвшинд;

4.1.2. Бараа, бүтээгдэхүүний бүлгийг тодорхойлохдоо Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын стандарт ангиллын 4 оронгийн түвшинтэй тохирох Бараа, бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын 5 оронгийн түвшинд;

4.1.3. Ажил мэргэжлийн үндсэн ангиллын 4 оронгийн түвшинд.

V. Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр, давтамж

5.1. Дотоод худалдааны статистикийн дараах үзүүлэлтийг тооцож, гаргана. Үүнд:

5.1.1. Нийт борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн “цэвэр борлуулалт”-ын нийлбэрээр тооцно. Цэвэр борлуулалт /үүнд электрон худалдааны борлуулалт орно/ гэдэг нь нийт борлуулалтаас борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хассан дүнг хэлнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар нэгтгэн гаргана.

5.1.2. Нийт орлогыг тайлант хугацаанд тухайн аж ахуйн нэгжид орсон худалдааны цэвэр борлуулалтын орлого болон үйл ажиллагааны бус орлогын нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр нэгтгэн гаргана.

5.1.3. Электрон худалдаагаар борлуулсан орлого Тухайн аж ахуйн нэгжийн зөвхөн дотоодод хийсэн электрон худалдааны борлуулалтыг энэ дүнд хамруулна. Тайлант хугацаанд электрон худалдаагаар борлуулсан орлогын нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик

(Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр нэгтгэн гаргана.

- 5.1.4. Борлуулсан барааны нийт өртөг. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн хувьд борлуулалтын өртөг нь барааг худалдан авсан үнэ юм. Тайлангийн хугацаанд борлуулсан барааны өртгийн /үүнд электрон худалдааны борлуулсан барааны өртөг орно/ нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.5. Электрон худалдаагаар борлуулсан барааны өртөг. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн хувьд электрон худалдаагаар борлуулсан барааг худалдаж авсан үнэ юм. Тухайн аж ахуйн нэгжийн зөвхөн дотоодод хийсэн электрон худалдааны борлуулсан барааны өртгийг энд багтаана. Тайлангийн хугацаанд электрон худалдаагаар борлуулсан барааны өртгийн нийлбэрээр тооцно. Электрон худалдаагаар борлуулсан барааны өртөгт тээвэрлэлт, хүргэлтийн зардлыг шингээсэн байна.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр нэгтгэн гаргана.

- 5.1.6. Нийт ашиг/алдагдал. Нийт орлого, зардлын зөрүүг ашиг/алдагдал гэх бөгөөд (+;-) нэмэх/хасах тэмдгээр илэрхийлэгдэнэ. Тайлант хугацаанд худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн “ашиг/алдагдал”-ын нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр нэгтгэн гаргана.

- 5.1.7. Нийт үйлдвэрлэлт. Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын бүтээгдэхүүнийг худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, барилга, байшин, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлогын (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг,

даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй) нийлбэрээр тооцно.

Худалдааны нэмэгдлийг дараах томъёогоор тооцно:

$$H=O-\Theta+Y_2-Y_1$$

H = Худалдааны нэмэгдэл

O = Худалдаж авсан бэлэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулсны орлого

Θ = Худалдаж авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний өртөг

Y₂ = Худалдан авсан бэлэн бараа, бүтээгдэхүүний жилийн эцсийн үлдэгдэл

Y₁ = Худалдан авсан бараа, бүтээгдэхүүний жилийн эхний үлдэгдэл.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.8. Завсрын хэрэглээний зардал. Худалдаа үйлчилгээгээ явуулахын тулд зарцуулсан материалын зардал (хөрөнгө оруулалтын зардал орохгүй) болон үйлчилгээний төлбөрийг завсрын хэрэглээний зардал гэж үзнэ. Үүнд: үндсэн, туслах материалын зардал, түүхий эд, цахилгаан эрчим хүч, дулаан, цэвэр, бохир ус, шатахуун, шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардал, барилга, гадны байгууллага, тээврээр үйлчлүүлсний төлбөр, барилга, байшин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал, албан томилолт, зар сурталчилгаа, шуудан, холбоо, интернэтийн зардал, эргэлтийн бус сав баглаа боодол, бичиг хэрэг, ном хэвлэлийн зардал, ажиллагчдын дахин сургалтын зардал, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, даатгал, харуул хамгаалалт, хөдөлмөр хамгааллын зардал, үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал (ногдол ашгийн зардал, валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн алдагдал орохгүй) зэрэг зардлыг хамруулна.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.9. Нэмэгдсэн өртөг. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдсэн өртгийг тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.10. Нийт кассын машины тоог тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн худалдааны үйл ажиллагаанд хэрэглэж байгаа кассын машины нийт тоогоор гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.11. Нийт хөргөгч, хөлдөөгчний тоог тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн худалдааны үйл ажиллагаанд хэрэглэж байгаа хөргөгч, хөлдөөгчний нийт тоогоор гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.12. Нийт сагсны тоог тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн худалдааны үйл ажиллагаанд хэрэглэж байгаа сагс /үүнд түрдэг тэргийг мөн хамруулна/-ны нийт тоогоор гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.13. Нийт ажилласан цаг (ажилласан цагийн үргэлжлэх хугацаа) нь тухайн худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нээх цагаас хаах цаг хүртэлх нийтэд үйлчилсэн хугацаа юм. Тухайн аж ахуйн нэгжийн нийт ажилласан цагийг ажлын цагийн үргэлжлэх хугацааны нийлбэрээр гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.14. Аж ахуйн нэгжийн тоо гэж тайлант хугацаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоогоор илэрхийлнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Бизнес регистрийн сангаас жил, улирлаар мэдээллийг авч гаргана.

- 5.1.15. Нийт цэгийн тоог тайлант хугацаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тоо, албан бус секторын тооцоонд хамрагддаг цэг (Чингэлэг, ТҮЦ, лангуу,

гутал засвар, авто засварын газар гэх мэт)-үүдийн тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Бизнес регистрийн сан, нийслэлийн статистикийн газраас жил бүр Улаанбаатар хотод явуулдаг “Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг цэгийн тоо” судалгааны үр дүн, Татварын ерөнхий газраас гаргадаг патентын татвар төлөгчдийн тайлангаас жилээр тооцон гаргана.

- 5.1.16. Жижиглэн худалдаа эрхэлдэг нийт цэгийн тоог тайлант хугацаанд бизнес регистрийн санд бүртгэлтэй жижиглэн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн тоо, албан бус секторын тооцоонд хамрагддаг цэг (Чингэлэг, ТҮЦ, лангуу, гутал засвар, авто засварын газар гэх мэт)-үүдийн тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Бизнес регистрийн сан, нийслэлийн статистикийн газраас жил бүр Улаанбаатар хотод явуулдаг “Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг цэгийн тоо” судалгааны үр дүн, Татварын ерөнхий газраас гаргадаг патентын татвар төлөгчдийн тайлангаас жилээр тооцон гаргана.

- 5.1.17. Худалдааны ашигтай талбай гэж худалдаа борлуулалт хийх, лангуу байрлуулахад зориулсан тухайн барилгын талбайн хэмжээг хэлнэ. Худалдааны ашигтай талбайд үйлчлүүлэгчийн ашиглах нийт талбай, түүний дотор хувцас солих өрөө, лангуу, цонхны эзлэх талбай, агуулах, түүнчлэн худалдагчийн зогсож ажилладаг лангууны арын талбай орно. Харин албан тасалгаа, бэлтгэлийн өрөө, засварын газар, шат, хонгил, хувцас өлгөх газар, амралтын зориулалттай бусад өрөө ордоггүй. Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээг тайлант хугацаанд худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн худалдааны ашигтай талбайн нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар нэгтгэн гаргана.

- 5.1.18. Нэг аж ахуйн нэгжид ногдох ажиллагчдын дундаж тоо. Тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн ажиллагчдын нийт тоог худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн тоонд харьцуулж гаргана.

$$\begin{array}{l} \text{Нэг аж ахуйн нэгжид ногдох} \\ \text{ажиллагчдын дундаж тоо} \end{array} = \frac{\text{Ажиллагчдын нийт тоо}}{\text{Нийт аж ахуйн нэгжийн тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик

(Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар тооцон гаргана.

- 5.1.19. Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо. Тайлант үеийн хүн амын тоог тухайн хугацааны худалдааны салбарын нийт цэгийн тоонд харьцуулж гаргана.

$$\frac{\text{Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо}}{\text{Нийт цэгийн тоо}} = \frac{\text{Хүн амын тоо}}{\text{Нийт цэгийн тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны бизнес регистрийн сан, жилийн эцсийн хүн амын тоо, нийслэлийн статистикийн газраас жил бүр Улаанбаатар хотод явуулдаг “Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг цэгийн тоо” судалгааны үр дүн, Татварын ерөнхий газраас гаргадаг патентын татвар төлөгчдийн тайлангаас жилээр тооцон гаргана.

- 5.1.20. Тухайн нутаг дэвсгэрт ногдох худалдааны цэгийн тоо. Тухайн нутаг дэвсгэрт байрладаг худалдааны нийт цэгийн тоог нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ /км²/-нд харьцуулж гаргана.

$$\frac{\text{Тухайн нутаг дэвсгэрт ногдох худалдааны цэгийн тоо}}{\text{Нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ /км}^2} = \frac{\text{Нийт цэгийн тоо}}{\text{Нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ /км}^2}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Тухайн газар нутгийн хэмжээг зохих байгууллагаас тогтоосон албан ёсны хэмжээг авна. ҮСХ-ны бизнес регистрийн сан, нийслэлийн статистикийн газраас жил бүр Улаанбаатар хотод явуулдаг “Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг цэгийн тоо” судалгааны үр дүн, Татварын ерөнхий газраас гаргадаг патентын татвар төлөгчдийн тайлангаас жилээр тооцон гаргана.

- 5.1.21. Нэг ажиллагчид ногдох борлуулалт. Тайлант хугацааны худалдааны нийт борлуулалтыг тухайн хугацаан дах худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоонд харьцуулж тооцно.

$$\frac{\text{Нэг ажиллагчид ногдох борлуулалт}}{\text{Нийт ажиллагчдын тоо}} = \frac{\text{Нийт борлуулалт}}{\text{Нийт ажиллагчдын тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар тооцон гаргана.

- 5.1.22. Нэг ажиллагчид ногдох нэмэгдсэн өртөг. Тайлант хугацааны худалдааны нэмэгдсэн өртгийг тухайн хугацаан дах худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг ажиллагчид ногдох нэмэгдсэн өртөг} = \frac{\text{Нэмэгдсэн өртөг}}{\text{Нийт ажиллагчдын тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.23. Нэг ажилласан цагт ногдох нэмэгдсэн өртөг. Тайлант хугацааны худалдааны нэмэгдсэн өртгийг тухайн хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажилласан цагийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг ажилласан цагт ногдох нэмэгдсэн өртөг} = \frac{\text{Нэмэгдсэн өртөг}}{\text{Нийт ажилласан цаг}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.24. Нэг ажиллагчид ногдох орлого. Тайлант хугацааны худалдааны нийт орлогыг тухайн хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг ажиллагчид ногдох орлого} = \frac{\text{Нийт орлого}}{\text{Нийт ажиллагчдын тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.25. Нэг ажилтны ажилласан дундаж хугацаа/цаг. Тайлант хугацааны худалдааны нийт ажилласан цагийг тухайн хугацаанд худалдааны

салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг ажиллагчид ногдох} = \frac{\text{Нийт ажилласан цаг}}{\text{ажилласан дундаж хугацаа}} \quad \text{Нийт ажиллагчдын тоо}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

- 5.1.26. Нэг аж ахуйн нэгжид ногдох кассын машины тоо. Тайлант хугацаанд худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн худалдааны үйл ажиллагаанд хэрэглэж байгаа кассын машины нийт тоог тухайн хугацааны худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг цэгт ногдох кассын} = \frac{\text{Нийт кассын машины тоо}}{\text{машины тоо}} \quad \text{Нийт аж ахуйн нэгжийн тоо}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

- 5.1.27. Нэг аж ахуйн нэгжид ногдох ашигтай талбай. Тайлант хугацаанд худалдааны ашигтай талбайн нийт хэмжээг тухайн хугацааны худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоонд харьцуулж тооцно.

$$\text{Нэг аж ахуйн нэгжид ногдох} = \frac{\text{Ашигтай тайлбай нийт хэмжээ}}{\text{ашигтай талбайн хэмжээ}} \quad \text{Нийт аж ахуйн нэгжийн тоо}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

- 5.1.28. Ашигтай талбайн нэг м²-тад ногдох дундаж борлуулалт. Тайлант хугацаанд худалдааны нийт борлуулалтыг тухайн хугацааны худалдааны ашигтай талбай /м²/-н нийт хэмжээнд харьцуулж тооцно.

$$\text{Ашигтай талбайн нэг м}^2 = \frac{\text{Нийт борлуулалт}}{\text{ногдох дундаж борлуулалт}} \quad \text{Нийт ашигтай тайлбай}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

- 5.1.29. Нэмэгдсэн өртгийн өсөлтийн хувь. Худалдааны салбарын аж ахуйн нэгжийн тайлант хугацаанд бий болгосон нэмэгдсэн өртгийг өмнөх хугацааны нэмэгдсэн өртөгт харьцуулсан харьцааг 100 хувиар үржүүлнэ.

$$\text{Нэмэгдсэн өртгийн өсөлтийн хувь} = \frac{\text{Тайлант хугацааны нэмэгдсэн өртөг}}{\text{Өмнөх хугацааны нэмэгдсэн өртөг}} \times 100\%$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.30. Худалдааны салбарын ажиллагчдын тооны өсөлтийн хувь. Тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоог өмнөх хугацаанд дахь худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоонд харьцуулсан харьцааг 100 хувиар үржүүлнэ.

$$\text{Ажиллагчдын тооны өсөлтийн хувь} = \frac{\text{Тайлант хугацааны ажиллагчдын тоо}}{\text{Өмнөх хугацааны ажиллагчдын тоо}} \times 100\%$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар тооцон гаргана.

- 5.1.31. Худалдааны ашиг ба нийт орлогын харьцаа. Тайлант хугацааны худалдааны нийт ашгийг тухайн хугацааны худалдааны нийт орлогод харьцуулж тооцно.

$$\text{Худалдааны ашиг ба нийт орлогын харьцаа} = \frac{\text{Нийт ашиг}}{\text{Нийт орлого}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик

(Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.32. Худалдааны ашиг ба нийт борлуулалтын харьцаа. Тайлант хугацааны худалдааны нийт ашгийг тухайн хугацааны худалдааны нийт борлуулалтад харьцуулж тооцно.

$$\frac{\text{Худалдааны ашиг ба нийт борлуулалтын харьцаа}}{\text{Нийт борлуулалт}} = \frac{\text{Нийт ашиг}}{\text{Нийт борлуулалт}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан) мэдээллээс жилээр тооцон гаргана.

- 5.1.33. Жижиглэн худалдааны нэг аж ахуйн нэгжид ногдох борлуулалт. Тайлант хугацааны жижиглэн худалдааны нийт борлуулалтыг тухайн хугацааны жижиглэн худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоонд харьцуулж тооцно.

$$\frac{\text{Жижиглэн худалдааны нэг цэгт ногдох борлуулалт}}{\text{Нийт борлуулалт}} = \frac{\text{Нийт борлуулалт}}{\text{Жижиглэн худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улирлын мэдээ) мэдээллээс жил, улирлаар тооцон гаргана.

- 5.1.34. Жижиглэн худалдааны үнийн ерөнхий индекс. Жижиглэн худалдааны үнийн ерөнхий индекс гэж дэд бүлгүүдийн үнийн өөрчлөлтийг тэдгээрийн нийт борлуулалтанд эзлэх хувийн жингээр жигнэж тооцсон индексийг хэлнэ.

Энэхүү индексийг “Жижиглэн худалдааны үнийн индекс тооцох аргачлал”-ын дагуу тооцон гаргана.

Жижиглэн худалдааны үнийн индексийн хувьд тайлант үеийн борлуулалтын бүтцийг тухай бүр тооцох боломжгүй учир жин тооцсон үе нь индексийн суурь үетэй давхцаж байдаг Ласпейресийн үнийн индексийг ихэвчлэн хэрэглэдэг. Жижиглэн худалдааны үнийн ерөнхий индексийг (1) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$PIL = \frac{\sum p_{nt} w_{no}}{\sum p_{no} w_{no}} \quad \text{буюу} \quad PIL = \frac{\sum p_i w_{no}}{\sum w_{no}} \quad (1)$$

PIL - үнийн ерөнхий индекс, Ласпейрес гэсэн англи хэллэгийн эхний үсэг

n – барааны нэр төрөл

t – тайлант үе

i – индекс

o – суурь үнэ

P_{nt} - n нэр төрлийн барааны тайлант үеийн үнэ

P_{no} - n нэр төрлийн барааны суурь үнэ,

P_i - барааны хувийн индекс

W_{no} - Экспорт, импортын нийт дүнд n нэр төрлийн барааны үнэ тус бүрийн эзлэх хувь, суурь үнээр

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Жижиглэн худалдааны үнийн мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

- 5.1.35. Жижиглэн худалдааны биет хэмжээний ерөнхий индекс. Жижиглэн худалдааны биет хэмжээний ерөнхий индекс гэж дэд бүлгүүдийн биет хэмжээний индексийн дунджаар илэрхийлэгдэнэ.

Жижиглэн худалдааны биет хэмжээний ерөнхий индексийг (2) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$QIP = \frac{\sum p_{no} q_{nt}}{\sum p_{no} q_{no}} \quad (2)$$

QIP - биет хэмжээний индекс, Пааше гэсэн англи хэллэгийн эхний үсэг

P_{no} - n нэр төрлийн барааны суурь үнэ

Q_{nt} – n нэр төрлийн барааны тайлант үеийн биет хэмжээ

Q_{no} – n нэр төрлийн барааны биет хэмжээ, суурь үнээр

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Энэ үзүүлэлтийг дотоод худалдааны салбарын үйл ажиллагааны албан ёсны статистик (Жижиглэн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн барааны нэр төрлийн татан авалт, эхний болон эцсийн үлдэгдлийн улирлын мэдээ) мэдээллээс улирлаар тооцон гаргана.

VI. Мэдээлэл цуглуулах

Дотоод худалдааны мэдээг цуглуулахдаа дараах үндсэн аргыг ашиглана.

Үүнд:

6.1. Статистикийн судалгаа. Статистикийн судалгаа нь худалдааны мэдээлэл цуглуулах үндсэн эх үүсвэр болдог. Статистикийн судалгааны давуу тал нь судалгааг төлөвлөж явуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулах ажлыг статистикийн байгууллага өөрөө хариуцан, хянаж явуулдагт оршино. Судалгаа явуулахад санхүүгийн болон хүн хүчний дутагдал, бэрхшээл учирдаг нь судалгаа явуулах сул тал нь юм. Статистикийн судалгаа нь эдийн засгийн тооллого, түүвэр судалгаа гэсэн төрлүүдтэй байна.

6.1.1. Эдийн засгийн тооллого. Уг тооллогыг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарыг хамарч ихэвчлэн 5-10 жил тутам явуулна. Эдийн засгийн судалгааны гол зорилго бизнес регистрийн санг шинэчлэн баяжуулахад оршино.

6.1.2. Худалдааны түүвэр судалгаа. Түүвэр судалгааг бөөний болон жижиглэнгийн худалдааны хувьд хамтад нь хийх, харин зарим гол үзүүлэлтээр ялгааг тусган явуулна. Үүнд:

- Үйл ажиллагааны хэлбэр, үзүүлэлтийн төрлөөр /орлого, зарлага, ажиллагчид, бусад онцлог үзүүлэлт/
- Газар зүйн байршил нь нэмэлт үзүүлэлт байж болно.

Тухайн үеийн эдийн засгийн хөгжлийн түвшингөөс хамаарч түүвэр судалгааг заримдаа орлогын тогтоосон хэмжээгээр хязгаарлан явуулж болно.

VII . Мэдээллийг хэрэглэгчдэд тархаах

7.1 Үндэсний статистикийн хорооноос дотоод худалдааны статистикийн мэдээллийг хэвлэмэл эсхүл цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаана.

7.2 Дотоод худалдааны статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд дараах үзүүлэлт болон танилцуулгаар тархаана. Үүнд:

7.2.1 Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт, оны үнээр, дэд салбараар;

7.2.2 Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт, оны үнээр, аймаг, нийслэлээр;

7.2.3 Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ;

7.2.4 Нэг аж ахуйн нэгжид ногдох худалдааны ашигтай талбай;

7.2.5 Худалдааны ашигтай талбайн нэг м²-т ногдох дундаж орлого;

7.2.6 Худалдааны салбарын нийт борлуулалт, үйлдвэрлэлт, оны үнээр;

7.2.7 Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо, бүс, аймаг, нийслэлээр, оны эцэст;

7.2.8 Дотоод худалдааны салбарын оны танилцуулга.

7.3 7.2.1-7.2.5-ыг улирал бүр, 7.2.6-7.2.8-ыг жилээр тархаана.

Дотоод худалдааны статистикийн үзүүлэлтийг тооцох хийсвэр жишээ

Энэхүү аргачлалын дагуу үзүүлэлтүүдийн тооцоог хийсвэр жишээгээр үзүүлье.

Дотоод худалдааны салбарын 2008 оны жилийн эцсийн мэдээг худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлангийн маягтаар мэдээллийг цуглуулж, нэгтгэсэн гэж үзье. Уг нэгтгэсэн мэдээллээр дараах үзүүлэлтүүд бидэнд мэдэгдэж байна. Мэдээнд хамрагдсан 1, 2 дугаар аж ахуйн нэгжүүд нь жижиглэн худалдаа эрхэлдэг гэж үзье.

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Нэгтгэсэн дүн	1-р аж ахуйн нэгж	2-р аж ахуйн нэгж	3-р аж ахуйн нэгж
Нийт орлого	мян.төг	44 995.2	14 060.5	7 770.0	23 164.7
Нийт борлуулалт	мян.төг	30 596.7	9 561.1	5 283.6	15 752.0
Электрон худалдаагаар борлуулсан орлого	мян.төг	11 030.0	230.0	0.0	10 800.0
Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	18 898.0	5 905.4	3 263.4	9 729.2
Электрон худалдаагаар борлуулсан барааны өртөг	мян.төг	5 450.0	150.0	0.0	5 300.0
Нийт ашиг	мян.төг	8 099.1	2 530.9	1 398.6	4 169.6
2008 оны нэмэгдсэн өртөг	мян.төг	10 798.8	3 374.5	1 864.8	5 559.5
2007 оны нэмэгдсэн өртөг	мян.төг	5 723.3	1 788.5	988.3	2 946.5
Нийт кассын машины тоо	ш	13	5	2	6
Нийт хөргөгч, хөлдөөгчний тоо	ш	6	1	0	5
Нийт сагсны тоо	ш	85	20	15	50
Нийт ажилласан цаг	мян.цаг	6.6	2.1	1.7	2.8
Худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ	м ²	255.0	45.0	40.0	170.0
Нийт ажиллагчдын тоо (2008 онд)	хүн	22	4	3	15
Нийт ажиллагчдын тоо (2007 онд)	хүн	15	3	2	10
Хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын нийт тоо буюу Бизнес регистрийн санд 2008 онд бүртгэлтэй худалдааны үйл ажиллагаа эрхэлсэн ААНБ-ын нийт тоо		3			
Бизнес регистрийн санд 2008 онд бүртгэлтэй жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлсэн ААНБ-ын нийт тоо		2			
Татварын Ерөнхий Газраас патентын татвар төлөгчдийн тоо (давхардсан)		10			

- **Худалдааны нийт цэгийн тоо:** 2008 онд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт тоо буюу 3, патентын татвар төлөгчдийн тоо буюу 10-ын нийлбэрээр тооцно.

Худалдааны нийт цэгийн тоо= 3+10=13

- **Жижиглэн худалдааны нийт цэгийн тоо:** 2008 онд жижиглэн худалдаа эрхэлсэн аж ахуйн нэгжийн нийт тоо буюу 2, патентын татвар төлөгчдийн тоо буюу 10-ийн нийлбэрээр тооцно.

Жижиглэн худалдааны нийт цэгийн тоо= 2+10=12

- **Нэг аж ахуйн нэгжид ногдох ажиллагчдын дундаж тоо:** 2008 онд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоо буюу 22-ийг, худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн тоо буюу 3-д харьцуулж гаргана.

$$\begin{array}{l} \text{Нэг аж ахуйн нэгжид ногдох} \\ \text{ажиллагчдын дундаж тоо} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Нийт ажиллагчдын тоо} \\ \text{Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо} \end{array}}{\begin{array}{l} 22 \\ 3 \end{array}} = \frac{22}{3} = 7.3 \approx 7$$

- **Нэг ажиллагчид ногдох борлуулалт:** 2008 онд худалдааны нийт борлуулалт буюу 30596.7 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоо буюу 22-т харьцуулж тооцно.

$$\begin{array}{l} \text{Нэг ажиллагчид ногдох} \\ \text{борлуулалт} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Нийт борлуулалт} \\ \text{Нийт ажиллагчдын тоо} \end{array}}{\begin{array}{l} 30596.7 \text{ мян.төг} \\ 22 \end{array}} = \frac{30596.7}{22} = 1390.8 \text{ мян.төг}$$

- **Нэг ажиллагчид ногдох нэмэгдсэн өртөг.** 2008 оны худалдааны нэмэгдсэн өртөг буюу 10798.8 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоо буюу 22-т харьцуулж тооцно.

$$\begin{array}{l} \text{Нэг ажиллагчид ногдох} \\ \text{нэмэгдсэн өртөг} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Нэмэгдсэн өртөг} \\ \text{Нийт ажиллагчдын тоо} \end{array}}{\begin{array}{l} 10798.8 \text{ мян.төг} \\ 22 \end{array}} = \frac{10798.8}{22} = 490.9 \text{ мян.төг}$$

- **Нэг ажиллагчид ногдох орлого.** 2008 оны худалдааны нийт орлого буюу 44995.2 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоо буюу 22-т харьцуулж тооцно.

$$\begin{array}{l} \text{Нэг ажиллагчид ногдох} \\ \text{орлого} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Нийт орлого} \\ \text{Нийт ажиллагчдын тоо} \end{array}}{\begin{array}{l} 44995.2 \text{ мян.төг} \\ 22 \end{array}} = \frac{44995.2}{22} = 2045.2 \text{ мян.төг}$$

- **Нэг ажилласан цагт ногдох нэмэгдсэн өртөг.** 2008 оны худалдааны нэмэгдсэн өртөг буюу 10798.8 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажилласан цагийн тоо буюу 6.6 мянган цагт харьцуулж тооцно.

$$\text{Нэг ажилласан цагт ногдох нэмэгдсэн өртөг} = \frac{\text{Нэмэгдсэн өртөг}}{\text{Нийт ажилласан цаг}} = \frac{10798.8 \text{ мян.төг}}{6.6 \text{ мянган цаг}} = 1636.2 \text{ төг / цаг}$$

- **Нэг аж ахуйн нэгжид ногдох кассын машины тоо:** 2008 онд худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн худалдааны үйл ажиллагаанд хэрэглэж байгаа кассын машины нийт тоо буюу 13 ширхэгийг, 2008 оны худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоо буюу 3-т харьцуулж тооцно.

$$\text{Нэг цэгт ногдох кассын машины тоо} = \frac{\text{Нийт кассын машины тоо}}{\text{Нийт аж ахуйн нэгжийн тоо}} = \frac{13 \text{ ш}}{3} = 4.3 \approx 4 \text{ ш}$$

- **Нэг аж ахуйн нэгжид ногдох ашигтай талбай:** 2008 онд худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ буюу 255.0 м²-г тухайн хугацааны худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоо буюу 3-т харьцуулж тооцно.

$$\text{Нэг аж ахуйн нэгжид ногдох ашигтай талбайн хэмжээ} = \frac{\text{Ашигтай тайлбай нийт хэмжээ}}{\text{Нийт аж ахуйн нэгжийн тоо}} = \frac{255.0 \text{ м}^2}{3} = 85 \text{ м}^2$$

- **Ашигтай талбайн нэг м²-тад ногдох дундаж борлуулалт.** 2008 онд худалдааны нийт борлуулалт буюу 30596.7 мян.төг-ийг тухайн хугацааны худалдааны ашигтай талбайн нийт хэмжээ буюу 255.0 м²-т харьцуулж тооцно.

$$\text{Ашигтай талбайн нэг м}^2 \text{ ногдох дундаж борлуулалт} = \frac{\text{Нийт борлуулалт}}{\text{Нийт ашигтай тайлбай}} = \frac{30596.7 \text{ мян.төг}}{255.0 \text{ м}^2} = 120.0 \text{ мян.төг/ м}^2$$

- **Жижиглэн худалдааны нэг аж ахуйн нэгжид ногдох борлуулалт.** 2008 оны жижиглэн худалдааны нийт борлуулалт буюу 14844.7 мян.төгрөгийг (1 болон 2 дугаар аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын нийлбэр), тухайн хугацаанд жижиглэн худалдааны нийт аж ахуйн нэгжийн тоо буюу 2-т харьцуулж тооцно.

$$\text{Жижиглэн худалдааны нэг цэгт ногдох борлуулалт} = \frac{\text{Нийт борлуулалт}}{\text{Жижиглэн худалдааны нийт цэгийн тоо}} = \frac{14844.7 \text{ мян.төг}}{2} = 7422.4 \text{ мян.төг}$$

- **Нэмэгдсэн өртгийн өсөлтийн хувь :** 2008 оны худалдааны салбарын нэмэгдсэн өртөг буюу 10798.8 мян.төгрөгийг, 2007 оны нэмэгдсэн өртөг буюу 5723.3 мян.төгрөгт харьцуулж, 100 хувиар үржүүлэн тооцно.

$$\text{Нэмэгдсэн өртгийн өсөлтийн хувь} = \frac{\text{2008 оны нэмэгдсэн өртөг}}{\text{2007 оны нэмэгдсэн өртөг}} \times 100\% = \frac{10798.8 \text{ мян.төг}}{5723.3 \text{ мян.төг}} \times 100\% = 188.7 \%$$

- **Худалдааны салбарын ажиллагчдын тооны өсөлтийн хувь:** 2008 онд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоо буюу 22-ийг 2007 оны худалдаа салбарын аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын тоо буюу 15-д харьцуулсан харьцааг 100 хувиар үржүүлж гаргана.

$$\text{Ажиллагчдын тооны өсөлтийн хувь} = \frac{2008 \text{ оны ажиллагчдын тоо}}{2007 \text{ оны ажиллагчдын тоо}} \times 100\% = \frac{22}{15} \times 100\% = 146.7\%$$

- **Худалдааны ашиг ба нийт орлогын харьцаа.** 2008 оны худалдааны нийт ашиг буюу 8099.1 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны нийт орлого буюу 44995.2 мян.төгрөгт харьцуулж тооцно.

$$\text{Худалдааны ашиг ба нийт орлогын харьцаа} = \frac{\text{Нийт ашиг}}{\text{Нийт орлого}} = \frac{8099.1 \text{ мян.төг}}{44995.2 \text{ мян.төг}} = 0.2$$

- **Худалдааны ашиг ба нийт борлуулалтын харьцаа.** 2008 оны худалдааны нийт ашиг буюу 8099.1 мян.төгрөгийг, тухайн хугацааны худалдааны нийт борлуулалт буюу 30596.7 мян.төгрөгт харьцуулж тооцно.

$$\text{Худалдааны ашиг ба нийт борлуулалтын харьцаа} = \frac{\text{Нийт ашиг}}{\text{Нийт борлуулалт}} = \frac{8099.1 \text{ мян.төг}}{30596.7 \text{ мян.төг}} = 0.3$$

- **Тухайн нутаг дэвсгэрт ногдох худалдааны цэгийн тоо.** Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт нийт 250 худалдааны цэг байдаг гэж үзээд, Сүхбаатар дүүргийн 1 км² нутаг дэвсгэрт ногдох худалдааны цэгийн тоог тооцож үзье. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн талбайн хэмжээг 208.4 км² гэж үзвэл, Сүхбаатар дүүргийн 1 км² нутаг дэвсгэрт ойролцоогоор худалдааны 1 цэг ногдож байна.

$$\text{Тухайн нутаг дэвсгэрт ногдох худалдааны цэгийн тоо} = \frac{\text{Нийт цэгийн тоо}}{\text{Нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ}} = \frac{250}{208.4 \text{ км}^2} = 1.2 \approx 1$$

**“А” аж ахуйн нэгжийн эрхэлж байгаа
үйл ажиллагааны чиглэл**

Хүснэгт 1

Салбар	Дэд салбар	Дэд бүлэг	Тодорхойлолт	Нийт орлогод дэд бүлгүүдийн эзлэх хувь
G	46	4620	Хөдөө аж ахуйн түүхий эд болон мал, амьтдын бөөний худалдаа	5%
		4630	Хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа	15%
	47	4730	Шатахууны жижиглэн худалдаа	3%
		4721	Хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	8%
		4722	Ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	23%
		4781	Захиалга, загвар танилцуулгаар хийгддэг хүнс, ундаа, тамхины жижиглэн худалдаа	13%
I	55	5510	Богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагаа	4%
	56	5621	Тусгай захиалгат хоолоор үйлчлэх	4%
		5630	Ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа	25%

Үндсэн үйл ажиллагааг тодорхойлохдоо **нэгдүгээрт** салбарыг, **хоёрдугаарт** дэд салбарыг, **гуравдугаарт** бүлгийг, **дөрөвдүгээрт** дэд бүлгийг тодорхойлно. Дээрхи “А” аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг /Хүснэгт 1/ дэд бүлгээс нь харахад 9 төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байна. Энэхүү “А” аж ахуйн нэгжийн хувьд нийт орлогод дэд бүлгүүдийн эзлэх хувиар үндсэн үйл ажиллагааг нь тодорхойлъё.

Хүснэгт 2

Салбарын тодорхойлох	Салбар G - Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	67 %
	Салбар I - Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	33%
Дэд салбарын тодорхойлох	Дэд салбар 46 – Машин, мотоциклээс бусад барааны бөөний худалдаа	20%
	Дэд салбар 47 – Машин, мотоциклээс бусад жижиглэн бөөний худалдаа	47%
Бүлгийг тодорхойлох	Бүлэг 473 - Шатахууны жижиглэн худалдаа	3%
	Бүлэг 472 - Хүнс, ундаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	31%
	Бүлэг 478 – Захиалга, загвар танилцуулгаар хийдэг жижиглэн худалдаа	13%
Дэд бүлгийг тодорхойлох	Дэд бүлэг 4721 - Хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	8%
	Дэд бүлэг 4722 - Ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	23%

Хүснэгт 2-оос харахад энэхүү аж ахуйн нэгжийн **үндсэн үйл ажиллагааг** ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, **хоёрдогч үйл ажиллагаа** нь ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа гэж тодорхойлно.

Үндэсний Статистикийн Хороо

-----oOo-----